

ХЯТАДЫН ЮАНИЙ ХАНШНЫ ӨӨРЧЛӨЛТ МАНАЙ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НЬ

**Мөнгөний бодлогын хэлтсийн ахлах эдийн засагч Р. Саранцэнэг.
Мөнгөний бодлогын хэлтсийн эдийн засагч Н. Ургамалсүвд.**

Оришил:

Манай улсын гадаад худалдааны гол түнш улсуудын нэг болох Хятад улс үндэсний валютын ханшаа сүүлийн 9 жилийн турш тогтмол барьж ирснийг бид бүхэн сайн мэднэ. Гэтэл сүүлийн саруудад Хятадын үндэсний валютын ханшны болзошгүй өөрчлөлтийн талаар олон улсын санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид таамаглан бичих боллоо. Энэ нь юаний ханшны өөрчлөлт дэлхийн томоохон хөрөнгө оруулагчид төдийгүй хөгжингүй болоод хөгжиж буй орнуудын эдийн засагт асар их нөлөөтэйн улмаас тэдгээрийн анхаарлыг зүй ёсоор татаж буй хэрэг юм. Өнгөрсөн 10 дугаар сард болсон G7 орнуудын уулзалтаар хүртэл Хятад улс юаний ханшаа аль болох түргэн хугацаанд чангаруулах шаардлагатайг авч хэлэлцсэнээс үзэхэд энэхүү асуудал нь хэрхэн дэлхий нийтийг хамарсан чухал асуудал болоод байгааг харуулж байна.

Өнөөдөр Хятад улсын эдийн засаг өдрөөс өдөрт маш хурдтайгаар өсөж байгаа бөгөөд ялангуяа гадаадын санхүүгийн хөрөнгө оруулалт асар хүчтэй нэмэгдэн, тэр хэмжээгээр валютын нийлүүлэлт дотоод зах зээлд нь байнга өсөн нэмэгдэж байна. Ийм нөхцөлд Хятад улс ханшаа удаан хугацаанд тогтмол барих нь түүнд улам бүр дарамт учруулах нь мэдээж.

Олон улсын зарим судлаачдын тооцоолж байгаагаар юаний ам.доллартай харьцах зах зээлийн бодит ханш нь одоогийн мөрдөж буй ханшаас даруй 40 хувиар чанга байгаа ажээ. Эдийн засагч нарын хэрэглэдэг Big Mac Индексээр бол АНУ дахь үнэ (дунджаар \$3)-тэй харьцуулахад Хятадад бургер хамгийн хямд буюу \$1.26 байдаг байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл юаний Big Mac-ийг худалдаж авах доллараар илэрхийлсэн ханш 58 хувиар доогуур тогтоогдсон байна гэсэн үг юм.

Хятадын гол худалдааны түнш болох Америкийн нэгдсэн улс юаний ам.доллартай харьцах ханш ийнхүү зах зээлийн журмаар байх ёстой хэмжээнээсээ

хамаагүй сул, түүнийг ийнхүү хиймлээр бага түвшинд барьж байгаа нь шударга бус хэрэг хэмээн буруушааж байна. Учир нь Хятадын экспорт Америкийн хэрэглэгчдэд хямдхан тусаж, харин Америкийн Хятад уруу гаргах экспорт илүү үнэтэй байгаагаас түүний хэмжээ нь буурч АНУ-ын гадаад худалдааны алдагдал улам бүр нэмэгдэх болсон байна. Өнгөрсөн оны 12 дугаар сард 9.9 тэрбум доллар байсан энэхүү алдагдал нь 1 дүгээр сар гэхэд 11.5 тэрбум доллар болж өсчээ.

Олон улсын санхүүгийн байгууллагууд Хятад улс үндэсний валютын ханшаа энэ оны эцэс эсвэл ирэх оны эхээр өөрчилнө гэсэн хүлээлттэй байсан боловч өнөөг хүртэл ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй байна. Саяхныг болтол Хятадын судлаачид болон Ардын банкны мэргэжилтнүүд юаний ханшийг заавал өөрчлөх шаардлага байхгүй гэсэн эсрэг байр суурь баримталж байсан боловч өнөөдөр байдал өөрчлөгджээ.

Санхүүгийн Меррилл Линч компаний өнгөрсөн 4 дүгээр сард хийсэн прогнозоор бол Хятад улс юаний ханшаа дор хаяж 10 хувиар чангаруулах юм байна. Өөрөөр хэлбэл 10 хувиар өөрчилсөн тохиолдолд 8.28 орчим юаньтай тэнцэж байсан нэг ам.доллар 7.4 орчим юаньтай тэнцэхээр болно гэсэн үг юм.

Хөрш орны төдийгүй гадаад худалдааны гол түншийн хувьд манай орны эдийн засагт юанийн ханшийн энэхүү өөрчлөлт хүчтэй нөлөөлөх нь дамжиггүй юм. Иймд юанийн ханшны энэхүү болзошгүй өөрчлөлтийн манай эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судалж, түүнээс урган гарах үр дагаврыг бид урьдчилан харахыг оролдсон юм.

Юаний ханшийг чангаруулах эдийн засгийн учир шалтгаан

Долларын эсрэг юаний ханшийг чангаруулах нь зөвхөн АНУ-ын гадаад худалдаанд ашигтай зүйл биш бөгөөд Хятад улсын өөрийнх нь эдийн засагт үүсэж бий болсон нөхцөл байдал үүнийг шаардаж байгаа юм.

Хятад улс ханшаа удаан хугацааны турш тогтвортой барьж байсан нь хөрөнгө оруулагч нарын итгэлийг хүлээх болж, ингэснээр ялангуяа сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ асар ихээр нэмэгдсэн юм. Энэ нь мэдээж эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, бүр хэт их өсөлт бий болгосон бөгөөд оны эхээр гэхэд өсөлт нь 9.8 хувьд хүрсэн байна. Гэвч энэхүү хэт их хөрөнгө оруулалтыг Хятадын эдийн засаг сүүл рүүгээ шингээх чадваргүй болж, улмаар инфляцийг өсгөхөд хүргэсэн. Учир нь хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр дотоодод валютын нийлүүлэлт мөн төдий хэмжээгээр нэмэгдэж байгаа тул зүй нь долларын ханш суларч, түүний эсрэг юань чангарснаар валютын зах зээл нь тэнцвэржих ёстой юм. Гэтэл Хятад улс ханшаа захиргаадан хүчээр тогтмол барьснаар юаньд эрэлтээс үүдсэн дарамт бий болж энэ нь улмаар инфляци үүсэх

гол шалтгаан болж байна. Өнөөдөр Хятад улс дахь инфляцийн түвшин 5 хувьд хүрчээ.

Ийнхүү Хятад улсын эдийн засгийн нөхцөл байдал нь өөрөө ханш чангарах ёстой гэсэн дохиог өгч эхлээд байна.

Юаний ханшийг чангаруулснаар Хятадын экспортын хэмжээ буурах боловч, эдийн засгийн хэт өсөлтийг сааруулан, инфляцийг бууруулах юм.

Хятадын эрх баригчид бий болоод байгаа инфляцийг сааруулах зорилгоор өнгөрсөн 9 жилийн хугацаанд анх удаа хүүгээ өсгөх бодлого явуулсан байна. Гэхдээ энэ бодлого нь инфляцийг бууруулах тал дээр олигтой үр дүнд хүрэхгүй нь мэдээж. Учир нь хүүгийн өндөр түвшин нь гадаадын хөрөнгө оруулалтыг улам ихээр татаж, ханшинд өөрчлөлт оруулаагүй цагт энэ нь мөн л эргээд юаньд дарамт учруулж инфляцийг улам хөөрөгдөж болзошгүй юм.

Манай улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөх вэ?

Манай улсын Хятад улстай хийдэг худалдааны эргэлтийн хэмжээг тоон үзүүлэлтээр харуулвал:

Хүснэгт 1. Хятад улстай хийсэн гадаад худалдааны хэмжээ, сая ам.доллараар

Жил	Гадаад худалдааны нийт эргэлт	Үүнээс Хятад улстай хийсэн нийт эргэлт		Нийт экспорт	Үүнээс Хятад улстай хийсэн экспорт		Нийт импорт	Үүнээс Хятад улстай хийсэн импорт	
		Үнийн дүн	эзлэх хувь, %		Үнийн дүн	эзлэх хувь, %		Үнийн дүн	эзлэх хувь, %
1989	1684.5	24.1	1.43	721.5	4.2	0.58	963	19.9	2.07
1990	1584.7	33.6	2.12	660.7	11.3	1.71	924	22.3	2.41
1991	708.9	69.1	9.75	348	52.8	15.17	360.9	16.3	4.52
1992	806.7	127	15.74	388.4	69.4	17.87	418.3	57.6	13.77
1993	761.6	186.1	24.44	382.6	120.2	31.42	379	65.9	17.39
1994	614.5	97.1	15.80	356.1	73.2	20.56	258.4	23.9	9.25
1995	888.6	122.3	13.76	473.3	77.8	16.44	415.3	44.5	10.72
1996	875.2	147	16.80	424.3	81	19.09	450.9	66	14.64
1997	1036.8	164.9	15.90	568.5	101.6	17.87	468.3	63.3	13.52
1998	965.6	176.7	18.30	462.3	110.1	23.82	503.3	66.6	13.23
1999	967	285.7	29.54	454.2	208.2	45.84	512.8	77.6	15.13
2000	1150.3	400.1	34.78	535.8	274.3	51.19	614.5	125.8	20.47
2001	1159.2	374.5	32.31	521.5	238.3	45.70	637.7	136.2	21.36
2002	1214.8	388.2	31.96	524	220.5	42.08	690.8	167.7	24.28
2003	1416.9	483.3	34.11	615.9	287.0	46.61	801.0	196.3	24.50
2004	1493.4	557.8	37.35	649.5	337.3	51.93	843.9	220.5	26.13

Нийт бараа эргэлтэнд Хятад улстай хийдэг худалдааны эзлэх хувийн жин жилээс жилд байнга өсөн нэмэгдэж байгаа бөгөөд хамгийн сүүлд 2004 оны 9 дүгээр сарын байдлаар 37.3 хувьд хүрээд байна.

Түүнчлэн нийт экспортонд Хятад улстай хийсэн экспортын эзлэх хувийн жин мөн үеийн байдлаар 51.9 хувь, нийт импортонд эзлэх жин нь 26.1 хувь

байгаагаас үзэхэд гол түншийн маань үндэсний валютын ханшинд хийгдэх гэж буй өөрчлөлт манай улсын эдийн засагт ч мөн хамаатай асуудал гэдэг нь ойлгомжтой.

Зөвхөн Хятад улстай хийдэг худалдааны хувьд манай улсын төлбөрийн тэнцэл ашигтай гардаг бөгөөд Хятад руу гаргах экспортын 71 хувийг зэсийн баяжмал, 20 хувийг малын түүхий эд эзэлдэг байна. Үүнээс гадна Хятад улстай албан бус секторынхон мөн тодорхой хэмжээгээр худалдаа хийдэг бөгөөд ханшийн болзошгүй өөрчлөлт тэдгээрийн бизнест мөн нөлөөлөх нь мэдээж.

Нэгэнт ханшийн тухай асуудал авч үзэж байгаа учраас дээрх экспорт, импорт нь дотроо чухам хичнээн нь юаниар, хичнээн нь доллараар хийгддэг вэ гэдгийг тодруулах нь чухал юм. Гадаад худалдааны статистикийн 2003-2004 оны мэдээллээс харахад өнгөрсөн оны дунджаар Хятадтай хийсэн:

Нийт экспортын:

51.1 хувь нь ам.доллараар,

0.19 хувь нь юаниар,

Нийт импортын:

11.8 хувь нь ам.доллараар

13.1 хувь нь юаниар тус тус хийгджээ.

/үлдсэн нь бараа солилцоо болон бусад валютаар: евро, рубль гэх мэт/.

Эндээс харахад манай улсын Хятад улстай хийдэг экспортын ихэнхийнх нь төлбөр ам.доллараар хийгддэг харин импортын хувьд доллар юаниар хийдэг төлбөр нь ойролцоо байдаг байна. Үүнээс ямар дүгнэлт хийж болох вэ гэвэл урд хөршийн маань мөнгөний ханш чангарах тохиолдолд манай зүгээс юаниар хийх худалдаа улам бүр багасаж, долларын гүйлгээ рүү шилжинэ гэсэн үг. Тиймээс дотоодод долларын эрэлт нэмэгдэж, түүний эсрэг төгрөгийн ханш нэмж сулрах магадлалтай.

Гэтэл нөгөө талаас юань чангарч байгаа тул Хятад улсад доллараа зарж юаниар хөрөнгөө байршуулах хүлээлт ихээр үүсэх бөгөөд энэхүү хүлээлт нь юаний эсрэг долларын бодит ханшийг сулрахад хүргэж болзошгүй юм.

Түүнчлэн юаний ханшийн чангаралтыг дагаад мэдээж түүний эсрэг төгрөгийн ханш сулрах нь лавтай. Ийнхүү ханшийн хувьд:

- Долларын эсрэг төгрөгийн ханш бага зэрэг суларна,
- Юаний эсрэг төгрөгийн ханш мөн пропорционалиар суларна.

Ханшийн өөрчлөлтийг дагаад дараагийн шатанд манай улсын гадаад худалдаа, эдийн засагт ямар өөрчлөлтүүд гарах вэ гэдгийг сайн, муу талаар нь нэгбүрчлэн тодорхойлохыг оролдъё.

Эерэг нөлөө нь:

1. Импорт үнэтэй болж ирэх тул түүнийг дагаад импортын хэмжээ багассанаас худалдааны алдагдал буурч болно.
2. Юаний чангаралт манай экспортыг урамшуулж хэмжээгий нь нэмэгдүүлнэ. Экспорт нэмэгдсэнээр гаднаас орж ирэх долларын нийлүүлэлт нэмэгдэх тул түүний эсрэг төгрөгийн ханшинд бага зэрэг нөлөөлж болох талтай /өөрөөр хэлбэл төгрөгийг бага зэрэг чангарахад хүргэж болзошгүй. Гэхдээ манай худалдааны овор хэмжээ бага тул ханшид сүртэй том нөлөө үзүүлж чадахгүй байх/. Ийнхүү экспорт нэмэгдэж, импорт буурснаар нийт худалдааны алдагдал багасах сайн талтай.
3. Хятадаас авах импортыг орлуулж болох дотоодын бүтээгдхүүний хувьд орлуулах нөлөөгөөр дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
4. Хятадаас орж ирэх шууд хөрөнгө оруулалтыг урамшуулж болно.

Сөрөг нөлөө нь:

1. Импорт үнэтэй болсноор хувцас, будаа, элсэн чихэр, жимс, ногоо зэрэг зайлшгүй импортолдог барааны дотоодын үнэ өснө.
2. Юаний чангаралт нь манай экспортыг урамшуулснаар ялангуяа малын түүхий эдийн эрэлтийг ихэсгэж, улмаар түүхий эдийн дотоодын үнэ өснө. Ингэснээр малын түүхий эдийг боловсруулан эцсийн бүтээгдхүүн хийдэг дотоодын үйлдвэрлэгчдийн зардлыг өсгөх болно.
3. Дотоодын орлуулах бүтээгдхүүний хувьд эрэлт нь ихэссэнээр ялангуяа дотоодын төмс, ногооны үнэ өсч болзошгүй.
4. Юаний чангаралтаас шалтгаалан Хятадаас импортолдог барилгын бүтээгдхүүний үнэ өсөх тул барилгын үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэнээр шинэ барилга, орон сууцны үнэ өсч болзошгүй. Гэхдээ одоогийн барилгын үйлдвэрлэлийн бизнес нэлээд их хэмжээний ашиг олдог гэж үздэг тул эрэлтийн хэмжээ, өрсөлдөөн, иргэдийн орон сууцаар хангагдаж байгаа байдал зэргээс шалтгаалаад үнэ нь төдийлөн өсөхгүй байж ч болох талтай. Гэхдээ ямар ч байсан манай иргэд, байгууллагууд хавар, зун, намрын улиралд байр, орон сууцандаа засвар их хийдэг тул тухайн засварын материалын үнэ өсөх нь дамжиггүй.
5. Ийнхүү шууд импортолдог болон эсвэл дотоодын орлуулах бүтээгдхүүнүүдийн үнэ өсөх шинжтэй байгаа нь эцсийн дүндээ инфляцийг өсгөнө гэсэн үг юм.
6. Инфляци өсөхөөр түүнийг дагаад гарах үр дагаврууд нь хүү өснө, мөнгөний нийлүүлэлт буурна, эдийн засгийн өсөлт багасна, ажилгүйдэл ихэсч, үйлдвэрлэл багассанаар орлого буурах явдал юм.

Дээрх таамаглалуудаас харахад ийнхүү муу нөлөө нь илт давамгайлахаар харагдаж байна. Үүний зэрэгцээ Хятадын эрх баригч нарын эдийн засгаа хэт халахаас сэргийлж зөөлөн газардуулах зорилгоор явуулж буй мөнгөний хумих бодлого нь манай эдийн засагт бас нөлөөгөө үзүүлэх болно. Энэхүү бодлогын нөлөөг мөн сайн муугаар нь ялгаж нэрлэвэл:

Муу тал нь:

- хатуу бодлогын үр дүнд Хятадын эдийн засгийн өсөлт буурснаар манай улсаас импортлох импортын хэмжээ нь багасаж болзошгүй, тухайлбал, манай улсаас импортлох зэсийн баяжмал, малын түүхий эдийн хэмжээг бууруулах нөлөө байхын зэрэгцээ тэдгээрийн дэлхийн зах зээл дээрх үнэ буурч болзошгүй нь экспортлогчийн хувьд манай улсад хохиролтой байх болно.
- Мөн Хятадаас оруулах шууд хөрөнгө оруулалтыг багасгах магадлалтай,

Сайн тал нь:

- Манай улс үйлдвэрлэдэггүй боловч Хятадын бусад улсаас их хэмжээгээр импортлодог бараа бүтээгдхүүний хувьд хатуу бодлогын нөлөөгөөр импортын хэмжээ нь багсах нь тэдгээр бараа бүтээгдхүүний эрэлтийн хэмжээг бууруулж, ингэснээр тэдгээрийн дэлхийн зах зээл дээрх үнэ буурахад хүргэнэ. Хэрэв манай улс тухайн бүтээгдхүүнийг импортлодог бол ийнхүү үнэ буурах нь манай улсад ашигтай байх нь мэдээж юм.

Хятад улсын өөрийнх нь байр суурь

Хятад улсын өөрийнх нь үзэж байгаагаар санхүүгийн зах зээл нь маш тогтворгүй байгаа учир юанийн ханшийг тогтвортой барьж байгаагийн хүчээр бизнес эрхлэгчдийн итгэлийг олж байгаа гэнэ. Түүгээр ч үл барам Хятадын төв банкны Дэд ерөнхийлөгч Ли Руогу хэлэхдээ юанийг байнга тогтмол түвшинд барьж байгаа нь ганц Хятад улсад биш дэлхий нийтэд ашигтай зүйл гэж мэдэгдэж байжээ.

Гэвч энэ оны 10 дугаар сарын 1-ний өдөр Хятад улс нь валютын ханшийн тогтолцоондоо өөрчлөлт хийж уян хатан, зах зээлд суурилсан ханшийн тогтолцоо руу аажмаар шилжихээ АНУ-д албан ёсоор мэдэгдсэн байна. Гэхдээ тодорхой цаг хугацаа зааж хэлээгүй байна. Учир нь Хятадын банкны секторт дорвитой реформ хийхгүйгээр ханшийн тогтолцоог өөрчилж болохгүй гэж үзэж байгаа нь банкны секторын чанаргүй зээлийн хэмжээ өнөөдөр 60 хувьд хүрээд байгаатай нь холбоотой ажээ. Ийнхүү санхүүгийн сектортоо шинэчлэлт хийхгүйгээр чөлөөтэй хөвөгч ханшийн тогтолцоонд шилжих нь хэтэрхий яарсан хэрэг болно гэж Хятадын эрх баригчид үзэж байна. Түүнчлэн Мерилл Линчийн үзэж байгаагаар

Хятад улс юаниа чангаруулахдаа зөвхөн ам.долларын хувьд биш харин хэд хэдэн улсын үндэсний валютаас бүрдсэн сагсны хувьд ханшаа уях байх гэж үзэж байгаа боловч Хятад улс өөрөө энэ талаар ямар ч үг дуугараагүй байна.

АНУ-ын хувьд юаний ханшийг чангаруулах явдлыг түргэсгэхийн төлөө авч болох цорын ганц арга бол Дэлхийн худалдааны байгууллагаар дамжуулан шударга бус худалдаа хийж байгаагийнх нь төлөө шимтгэл авах нь зөв гэж интернетийн саяхны нэгэн мэдээн дээр дурдсан байна.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэж хэлвэл урд хөршийн маань үндэсний валютын ханшийн чангаралт манайд сайн, муу аль аль талын нөлөө үзүүлэхээр байгаа боловч голчилж сөргөөр нөлөөлөхөөр байна. Хятад улстай түншилдэг бусад олон орнууд ханшийн энэхүү өөрчлөлт тэдгээр орны эдийн засагт сайнаар нөлөөлнө гэж үзэж байна. Гэвч манай улсын хувьд бид дээр хийсэн таамаглалууд дээрээ үндэслэн муу нөлөө нь давамгайлна гэсэн дүгнэлтийг гаргаж байна. Гэхдээ Хятад улс энэхүү өөрчлөлтөө ямар ч байсан маш ойрын ирээдүйд хийхгүй бололтой.